

ШИЛЭН ДАНСНЫ 2017 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

*Санхүүгийн хяналт аудитын
алба*

- “Шилэн дансны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж зааснаар манай алба шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

- Тус алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд тухайн жилийн төсөв, сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан эсэхэд хяналт тавьлаа. Шилэн дансанд мэдээлэл байршуулахаар хуульд заагдсан
- Төсөвт байгууллага 176
- Сан 3
- Төрийн өмчит аж ахуйн нэгж 2
- Хувийн аж ахуйн нэгж 71
- Орон нутгийн амчит аж ахуйн нэгж 4
- Нийт 256

Шилэн дансны цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тогтоол батлагдсан байна.

Тогтоолоор цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг журмаар зохицуулсан.

Журмын дагуу мэдээллийг байршуулахдаа зарим байгууллагууд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хугацаа хожимдож оруулах, мэдээлээгүй зөрчил гарсаар байна.

	Мэдээлэл тавьсан байгууллагын тоо	Нийт мэдээлсэн тоо	Үүнээс хоцроож мэдээлсэн тоо
Төсөвт байгууллага	176	25200	2741
Сан	3	513	46
Төрийн өмчит ААН	2	124	49
Хувийн ААН	71	2182	771
ОНӨААН	4	440	181

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх мэдээлэл

	Мэдээлсэн байдал	мэдээлээгүй
Булган аймгийн харьяат ААН	18	2
Бусад харьяат	0	43

Төрийн бус байгууллагаас аймгийн шилэн дансны мэдээллийг дараах 4 байгууллагаар төлөөлүүлэн дүгнэж байна.

		Нэгдсэн сайтад мэдээлсэн байдал	Мэдээллийн самбараар мэдээлсэн байдал
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	14 мэдээлэл хоцроож мэдээлсэн	Самбаргүй
2	Булган сумын Засаг даргын Тамгын газар	5 мэдээлэл хоцроож мэдээлсэн	Самбаргүй
3	Булган МЭЭЖХХК	6 мэдээлэл хоцроож мэдээлсэн	Самбараар мэдээлсэн
4	Булган АЗЗАТӨХК	43 мэдээлэл хоцроож мэдээлсэн	Самбаргүй

Авсан арга хэмжээ

- Шилэн дансанд мэдээлэл байршуулах, хяналт тавих талаар сургалт зохион байгуулсан.
- Хагас бүтэн жилээр шилэн дансны тайланг ИТХТ, Засаг даргын зөвлөлд мэдээлсэн.
- 2017 оны хагас жилийн тайлангаар мэдээллээ байршуулаагүй 124 байгууллагын нэрсийг гарган аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.
- Зөвлөмж боловсруулан сайт, нүүр номондоо мэдээлсэн.
- Сар бүр дотоод хяналт хэрэгжүүлсэн

Цаашид анхаарах

- Аймаг, сумын хурлын төлөөлөгч нартай хамтарсан хяналт шалгалт хийх.
- Сумын хурлын жил улирлын төлөвлөгөөнд шилэн дансны нэгдсэн сайт болон мэдээллийн самбарт мэдээлсэн байдалд хяналт шалгалт хийх талаар тусгуулах.
- Боловсруулан мөрдөж байгаа дэвтрийг бүрэн хөтлүүлэх.
- Хоцроосон болон мэдээлээгүй ажилтнуудад хариуцлага тооцох